ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН 24 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:** ӨМА-2026/118/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Шижирболд<br>Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn<br>Аудитор: Т.Будсүрэн<br>Утас: 70533552 Цахим хаяг: Budsurent@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ……………………………………..……………..……3-4

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
   - 2.1 Аудит хийсэн байдлын тайлан ………………………………………………….…………...5
   - 2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ……………………………………..……………......6-7
   - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ……………………………………………….7-8
   - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан …………………....……….8
   - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ……………………..…………..……..….8-9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
   - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ……………………………..………..…………..9
   - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ……………………………………..……………..9
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ………...………………………...………9
   - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ……..…9-11
   - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл ………………………………………………………..11
     - 3.5.1 Төсвийн төлөвлөлт ……………………………………………..……..……11
     - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл ……………………………………………….……..……..11
     - 3.5.3 Нэмэлт төсөв ………………………………………………………..……………12
     - 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ……………………………………..…12

4. АУДИТЫН ТАЙЛАН
   - 4.1 Ерөнхий зүйл ……………………...……………………………………..………………..12
   - 4.2 Материаллаг байдал …………………………………………………………….…………12
   - 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт …………………………………….…13
   - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ……….....13
     - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ……………………………...……...…13
     - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ……………………………………………...13
   - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт …………………….………..13
     - 4.5.1 Завсрын аудитын талаар ……………………………………………..………..13
     - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ……..……13
   - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ………………………………………………13

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
   - 5.1 Төлбөрийн акт ...........................................................................................................14
   - 5.2 Албан шаардлага .......................................................................................................15
   - 5.3 Зөвлөмж .......................................................................................................................15

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........................................16-17


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 167

танай ______________ -ны № ______________ -т

ДАЛАНЗАДГАД СУМЫН 24 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БОЛОРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,014,771.6 мянган төгрөгийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад орж 2 бүлэг шинээр нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 124,810.5 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 151,030.0 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал, 47,506.7 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 129,907.8 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 160,207.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэн байна.

4626050244

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4 | 212,108,323.61 | 42,244,604.64 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | | 212,108,323.61 | 42,244,604.64 |
| **3121** | **Төгрөг** | | 212,108,323.61 | 42,244,604.64 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | | 212,108,323.61 | 42,244,604.64 |
| **33** | **АВЛАГА** | 5 | 7,228.08 | 68,878.87 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 7,228.08 | 68,878.87 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6 | 103,012,629.12 | 126,605,179.12 |
| **351** | **Түүхий эд материал** | | 877,344.00 | 877,344.00 |
| 35130 | Эм боох материал | | 877,344.00 | 877,344.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 102,135,285.12 | 125,727,835.12 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 2,471,500.00 | 2,880,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 3,716,000.00 | 4,479,000.00 |
| 3546 | Хүнсний материал | | 5,149,480.00 | 1,420,180.00 |
| 3545 | Барилгын засварын материал | | 40,000.00 | |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 90,758,305.12 | 116,948,655.12 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **315,128,180.81** | **168,918,662.63** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7 | 3,041,680,294.69 | 3,053,224,753.23 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 2,902,461,544.69 | 2,912,756,003.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 2,940,995,489.00 | 2,940,995,489.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (220,664,304.54) | (303,200,459.70) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 134,089,620.60 | 199,138,442.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (41,789,832.93) | (66,048,649.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 106,720,145.00 | 190,749,145.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (31,824,436.02) | (68,784,474.23) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 43,025,100.00 | 31,955,100.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (28,090,236.42) | (12,048,589.82) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 139,218,750.00 | 140,468,750.00 |
| 39301 | Программ хангамж | | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,250,000.00) | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 139,218,750.00 | 139,218,750.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **3,041,680,294.69** | **3,053,224,753.23** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **3,356,808,475.50** | **3,222,143,415.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **30,323.74** | **-** |
| **413** | **Өглөг** | | **30,323.74** | |
| 4131 | Ажилчидтай холбоотой өглөг | | 30,323.74 | |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **3,356,778,151.76** | **3,222,143,415.86** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 509,484,469.82 | 509,484,469.82 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,554,571,863.72 | 2,419,937,127.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 2,554,571,863.72 | 2,554,571,863.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | | (134,634,735.90) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 292,721,818.22 | 292,721,818.22 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **3,356,778,151.76** | **3,222,143,415.86** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **3,356,808,475.50** | **3,222,143,415.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,129,728,500.00** | **1,256,200,600.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,054,707,800.00 | 1,117,345,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,054,707,800.00 | 1,117,345,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхжүүжих | 75,020,700.00 | 138,855,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага | 75,020,700.00 | 138,855,000.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,312,367,710.39** | **517,411,125.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,312,367,710.39 | 517,411,125.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 266,367,792.79 | 341,334,523.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагаанаас санхүүжих | 252,552,292.79 | 322,530,083.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,815,500.00 | 18,804,440.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,043,703,517.60 | 160,907,352.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,296,400.00 | 15,169,250.00 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,442,096,210.39** | **1,773,611,725.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,308,727,951.71** | **1,908,246,460.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,247,409,882.42** | **1,894,597,721.09** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 796,568,709.24 | 1,246,249,314.88 |
| 210101 | Үндсэн цалин | 514,423,634.87 | 777,371,182.85 |
| 210102 | Нэмэгдэл | 246,709,944.37 | 386,504,737.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 28,425,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,435,130.00 | 53,948,394.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **101,332,771.37** | **155,383,176.56** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,179,198.88 | 105,585,000.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,132,386.40 | 12,269,045.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,013,392.97 | 6,308,109.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,999,019.97 | 6,261,294.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,008,773.15 | 24,959,726.07 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **53,553,103.71** | **129,907,810.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,228,970.78 | 12,586,379.39 |
| 210302 | Түлш, халаалт | 30,547,637.93 | 104,541,710.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,776,495.00 | 12,779,720.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,993,172.00** | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 12,993,172.00 | |
| **2105** | **Норматив зардал** | **151,951,720.00** | **165,027,890.00** |
| 210502 | Хоол, хүнс | 151,951,720.00 | 165,027,890.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,799,600.00** | **2,997,350.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,799,600.00 | 2,997,350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,999,400.00** | **4,995,236.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,999,400.00 | 4,955,236.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **121,211,405.10** | **190,076,943.46** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,823,450.00 | 14,697,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,346,300.00 | 1,170,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 90,041,655.10 | 174,209,333.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,318,070.29** | **13,648,739.81** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,850,074.00 | 7,698,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,850,074.00 | 7,698,900.00 |
| 2133 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,467,996.29 | 5,949,839.81 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,467,996.29 | 5,949,839.81 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,308,727,951.71** | **1,908,246,460.90** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,133,368,258.68** | **(134,634,735.90)** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,070,583.52 | |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(5,070,583.52)** | |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,128,297,675.16** | **(134,634,735.90)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,382,280,792.79** | **1,578,730,683.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 252,552,292.79 | 322,530,083.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 252,552,292.79 | 322,530,083.00 |
| 120009 | Бусад орлого | 252,552,292.79 | 322,530,083.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 252,552,292.79 | 322,530,083.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,129,728,500.00** | **1,256,200,600.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,054,707,800.00 | 1,117,345,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,054,707,800.00 | 1,117,345,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 75,020,700.00 | 138,855,000.00 |
| 132001 | Урсгалт үйл ажиллагааны орлого | 75,020,700.00 | 138,855,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,229,399,916.73** | **1,742,552,401.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,229,399,916.73** | **1,742,552,401.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,168,081,846.44** | **1,728,903,662.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **797,356,826.92** | **1,246,242,086.80** |
| 210101 | Үндсэн цалин | 501,014,825.56 | 777,363,954.77 |
| 210102 | Нэмэгдэл | 260,737,106.77 | 386,504,737.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 28,425,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,604,894.59 | 53,948,394.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **100,469,895.81** | **155,482,379.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,174,995.07 | 105,684,203.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8.337,820.90 | 12,269,045.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,965,993.09 | 6,308,109.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,547,857.31 | 6,261,294.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,443,229.44 | 24,959,726.07 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **53,553,103.71** | **129,907,810.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,228,970.78 | 12,586,379.39 |
| 210302 | Түлш, халаалт | 30,547,637.93 | 104,541,710.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,776,495.00 | 12,779,720.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **154,157,970.00** | **161,298,590.00** |
| 210502 | Хоол, хүнс | 154,157,970.00 | 161,298,590.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,999,600.00** | **2,997,350.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,999,600.00 | 2,997,350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,999,400.00** | **4,955,236.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,999,400.00 | 4,955,236.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,545,050.00 | 28,020,210.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,315,250.00 | 21,851,610.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,229,800.00 | 6,168,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,318,070.29** | **13,648,739.81** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,850,074.00 | 7,698,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,850,074.00 | 7,698,900.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,467,996.29 | 5,949,839.81 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **152,880,876.06** | **(163,821,718.97)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **6,042,000.00** |
| | Дотоод эх үүсвэрээр | | 6,042,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 6,042,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(6,042,000.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **152,880,876.06** | **(169,863,718.97)** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 212,108,323.61 |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 42,244,604.64 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 509,484,469.82 | 292,721,818.22 | 2,554,571,863.72 | 3,356,778,151.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (134,634,735.90) | (134,634,735.90) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **509,484,469.82** | **292,721,818.22** | **2,419,937,127.82** | 3,222,134,415.86 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,256,140,600.00** | **1,250,250,760.19** | 5,889,839.81 | 99.53 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,117,285,600.00 | 1,117,345,600.00 | (60,000.00) | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,117,285,600.00 | 1,117,345,600.00 | (60,000.00) | 100.00 |
| 132 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 138,855,000.00 | 132,905,160.19 | 5,949,839.81 | 95.72 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 138,855,000.00 | 132,905,160.19 | 5,949,839.81 | 95.72 |
| 120004 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 534,681,600.00 | 322,530,083.00 | 212,151,517.00 | 60.32 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 353,329,200.00 | 322,530,083.00 | 30,799,117.00 | 91.28 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 181,352,400.00 | | 181,352,400.00 | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,790,822,200.00** | **1,572,780,843.19** | 218,041,356.81 | 87.82 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,790,822,200.00** | **1,730,560,562.16** | 60,261,637.84 | 96.63 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,783,123,300.00** | **1,722,861,662.16** | 60,261,637.84 | 96.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,266,985,700.00** | **1,246,242,086.80** | 20,743,613.20 | 98.36 |
| 210101 | Үндсэн цалин | 815,811,700.00 | 777,363,954.77 | 38,447,745.23 | 95.29 |
| 210102 | Нэмэгдэл | 419,634,200.00 | 386,504,737.66 | 33,129,462.34 | 92.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 28,425,000.00 | (28,425,000.00) | |
| 210104 | Урамшуулал | 31,539,800.00 | 53.948,394.37 | (22,408,594.37) | 171.05 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **148,552,500.00** | **155,482,379.17** | (6,929,879.17) | 104.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 101,024,000.00 | 105,684,203.35 | (4,660,203.35) | 104.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,885,700.00 | 12,269,045.00 | (383,345.00) | 103.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,944,700.00 | 6,308,109.98 | (363,409.98) | 106.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,944,700.00 | 6,261,294.77 | (316,594.77) | 105.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,753,400.00 | 24,959,726.07 | (1,206,326.07) | 105.08 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **135,855,000.00** | **129,907,810.19** | 5,947,189.81 | 95.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,870,700.00 | 12,586,379.39 | 5,284,320.61 | 70.43 |
| 210302 | Түлш, халаалт | 104,315,400.00 | 104,541,710.80 | (226,310.80) | 100.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,668,900.00 | 12,779,720.00 | 889,180.00 | 93.49 |
| **2105** | **Норматив зардал** | **185,983,100.00** | **161,298,590.00** | 24,684,510.00 | 86.73 |
| 210502 | Хоол, хүнс | 185,983,100.00 | 161,298,590.00 | 24,684,510.00 | 86.73 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **2,997,350.00** | 2,650.00 | 99.91 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,997,350.00 | 2,650.00 | 99.91 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,976,700.00** | **4,955,236.00** | 21.464.00 | 99.57 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 4,976,700.00 | 4,955,236.00 | 21,464.00 | 99.57 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **37,770,300.00** | **21,978,210.00** | 15,792,090.00 | 58.19 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,575,700.00 | 18,834,610.00 | 9,741,090.00 | 65.91 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,194,600.00 | 3,143,600.00 | 6,051,000.00 | 34.19 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,698,900.00** | **7,698,900.00** | | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,698,900.00 | 7,698,900.00 | | 100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 1,790,822,200.00 | 1,730,560,562.16 | 60,261,637.84 | 96.63 |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **42,244,604.64** | **42,244,604.64** | - |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 180,595.4 мянган төгрөгийн алдаа[5] илэрснээс аудитын явцад 180,595.4 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан,
- Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 18,804.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд Унаа хоолны хөнгөлөл /210103/ зардлыг 25.0 мянган төгрөг, Урамшуулал /210104/ зардлыг 652.9 мянган төгрөг, Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал /213209/ зардлыг 769.8 мянган төгрөгийг тус тус зөрүүтэй илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулган баталгаажуулахад 157,779.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 671.4 мянган төгрөг, НДШ-ийн өглөгийг 1,807.0 мянган төгрөг, Шуудан холбооны өглөг 85.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан.

Энэ нь УСНББОУС-1,"Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 1,874.6 мянган төгрөгийн зөрчил[5] илэрснээс 68.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1,332.0 мянган төгрөгийн 1 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага, 473.7 мянган төгрөгийн төлбөрийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлсэн.

**ТӨЛБӨРИЙН АКТ:**

*Илрүүлэлт:* Тайлант онд "Сэтгэгч-2025" оюун ухааны наадмын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд илүү цагаар ажилласан албан хаагчдад хөлс олгохдоо жагсаалтад ороогүй 6 багшид 473.7 мянган төгрөг олгосон байна

*Энэ нь* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн *91.3-д "Ажлын бүтэн бус цагаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд заасан ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журам"-ын *4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"*

**5.2 АЛБАН ШААРДЛАГА:**

*Илрүүлэлт:* Тайлант онд нягтлан бодогч, няравт 1,332.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т *"хариуцлагатай байх",* 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Хууль тогтоож, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх

**5.3 ЗӨВЛӨМЖ:**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт:* Тайлант онд НДШ-ийн 68.8 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна..

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөх

*Илрүүлэлт:* Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 32 нэр төрлийн 18,468.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгах, сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн эрх бүхий газарт хүргүүлэн шийдвэрлэж ажиллах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

***Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*** *\/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан. | 1 | - | | | 1 | - | 1 | - | | | | |
| Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 18,804.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, | 1 | 18,804.4 | | | 1 | 18,804.4 | 1 | 18,804.4 | | | | |
| Үр дүнгийн тайланд Унаа хоолны хөнгөлөл /210103/ зардлыг 25.0 мянган төгрөг, Урамшуулал /210104/ зардлыг 652.9 мянган төгрөг, Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал /213209/ зардлыг 769.8 мянган төгрөгийг тус тус зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 1,447.8 | | | 1 | 1,447.8 | 1 | 1,447.8 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулган баталгаажуулахад 157,779.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 157,779.7 | | | 1 | 157,779.7 | 1 | 157,779.7 | | | | |
| Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 671.4 мянган төгрөг, НДШ-ийн өглөгийг 1,807.0 мянган төгрөг, Шуудан холбооны өглөг 85.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан. | 1 | 2,563.4 | | | 1 | 2,563.4 | 1 | 2,563.4 | | | | |
| **Дүн** | **5** | **180,595.4** | | | **5** | **180,595.4** | **5** | **180,595.4** | | | | |

***Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/т/тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд "Сэтгэгч-2025" оюун ухааны наадмын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд илүү цагаар ажилласан албан хаагчдад хөлс олгохдоо жагсаалтад ороогүй 6 багшид 473.7 мянган төгрөг олгосон байна | 1 | 473.7 | 1 | 473.7 | | | | | | | | |
| Тайлант онд нягтлан бодогч, няравт 1,332.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон байна. | 1 | 1,332.0 | | | 1 | 1,332.0 | | | | | | |
| Тайлант онд НДШ-ийн 68.8 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан байна. | 1 | 68.8 | | | | | 1 | 68.8 | | | | |
| Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 32 нэр төрлийн 18,468.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. | 1 | 18,468.2 | | | | | 1 | 18,468.2 | | | | |
| **ДҮН** | **4** | **1,874.6** | **1** | **473.7** | **1** | **1,332.0** | **2** | **18,537.0** | | | | |

***Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал***

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг тус тус байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |
| **Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |